**ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН ДЭРГЭДЭХ ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ЁС ЗҮЙН САЛБАР/ ХЭСЭГ/ БАГИЙН ХОРООГ ЧАДАВХЖУУЛАХ СУРГАЛТЫН ТАЙЛАН**

**ЗОРИЛГО:** Эрүүл мэндийн салбарын хэмжээнд ёс зүйн зөрчлийг үл тэвчих сэтгэлгээ, шударга байдлыг эрхэмлэхэд чиглэсэн соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлэх, ёс зүйн хэм хэмжээг сахиулах, зөрчлийг хянан шийдвэрлэх менежментийг сайжруулах, ёс зүйгээр үлгэрлэсэн байгууллагын соёлыг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

**ХУГАЦАА:** 2026 оны 03 сарын 12-ны өдөр 10.30-12.30 цагт

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн дэргэдэх салбар хорооны бүрэлдэхүүн төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, өргөдөл гомдлыг хянан шийдвэрлэхэд анхаарах асуудал, тохиолдол дээр ажиллах байдлаар чадавхжуулах сургалтад хамрагдав.

**ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН ГАЗАР:**

Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн захиргааны 4 давхар, Эрдмийн зөвлөл

**ОРОЛЦОГЧИД:**

Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн дэргэдэх эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооны нийт гишүүдээс 66% нь тус сургалтад хамрагдсан.

**СУРГАЛТЫН АГУУЛГА:**

Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, ёс зүйн зөрчилтэй холбоотой өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэхэд анхаарах асуудлуудын талаар мэдээлэл өгч, бодит тохиолдолд тулгуурласан жишээн дээр ажиллах хэлбэрээр зохион байгуулагдсан ба ёс зүйн зөрчлийг урьдчилан сэргийлэх, зөрчлийг шийдвэрлэх үйл ажиллагаанд баримтлах зарчим, ёс зүйн хорооны үүрэг хариуцлага, шийдвэр гаргах үйл явцын талаар оролцогчид санал солилцож, мэдлэг мэдээллээ нэмэгдүүлэв.

**СУРГАЛТЫН ҮР ДҮН:**

- Ёс зүйн хорооны гишүүдийн ёс зүйн хууль, эрх зүйн талаарх мэдлэг, ойлголт нэмэгдэв.
- Ёс зүйн зөрчилтэй холбоотой өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх үйл явцад анхаарах асуудлуудын талаар нэгдсэн ойлголттой болов.
- Бодит тохиолдолд суурилсан хэлэлцүүлгээр дамжуулан асуудлыг шинжлэх, шийдвэрлэх ур чадвар дээшлэв.
- Байгууллагын хэмжээнд ёс зүйд суурилсан эерэг соёлыг төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлэх ач холбогдолтой арга хэмжээ боллоо.

**ДҮГНЭЛТ:**

Энэхүү чадавхжуулах сургалт нь ёс зүйн салбар хорооны гишүүдийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх үйл ажиллагааг илүү үр дүнтэй хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой сургалт боллоо.

**ХАВСРАЛТ:**


integrity
principles
moral
honesty
ETHICS
honor
choice
БАТЛАМЖ


600
50
230
60
236
24